| <b>ҮҮРЭГ АМЛАЛТЫН ДУГААР НЭР:</b> 8. Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бурдуулэх |                                     |  |
| <b>Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо /Шинээр дэвшиж буй зорилт уу, эсхүл хэрэгжих буй зорилт уу?/</b>             |                                     | 2019.01.15-2021.01.15  |
| <b>Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг</b>  |                                     | Хэрэгжиж буй зорилт  |
| <b>Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр</b>   |                                     | Хууль зүй, дотоод хэргийн яам  |
| <b>Газар хэлтсийн нэр</b>   |                                     | Төрийн нарийн бичгийн дарга  |
| <b>И-мэйл хаят</b>  |                                     | Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг   |
| <b>Утас</b>   |                                     | Хууль зүйн бодлогын газар  |
|   |                                     | sainzorig@mojha.gov.mn   |
|   |                                     | 261957, 88110079   |
| <b>Бусад оролцогч талууд</b>  | <b>Яам, агентлаг</b>                | Үндэсний Аудитын газар, Татварын ерөнхий газар, Авиилгатай тэмцэх газар, Сонгуулийн Ерөнхий Хороо  |
|   | <b>Иргэний нийгмийн байгууллага</b> | Төрийн ил тод байдал, авилга, засаглалын асуудлаар судалгаа, шинжилгээ хийн идэвхтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд, МҮОНРТ, Улс төрийн намууд, Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын Боловсрол Төв, "Шилэн нам" авилгын эсрэг түншлэл |
| <b>Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт</b>  |                                     | Тус зорилт 2016-2018 оны НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан боловч тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй, 2016 онд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн                        |

|  |   |
|--|---|
|  | <p>найруулгын төслийг 2012-2016 оны УИХ бүрэн эрхийн хугацаандаа хэлэлцэж амжаагүй тул буцаасан байна.</p> <p>Иймд Монгол Улсын Засгийн газраас тус хуулийн төслийг санаачлан, УИХ-д өргөн мэдүүлэх, ач холбогдлыг олон нийтэд танилцуулах, тэдний дэмжлэгийг өргөжүүлэх ажлыг яаралтай зохион байгуулах шаардлагатай байна.</p> <p>Түүнчлэн өмнөх хуулийн төсөлд тусгагдсан дэвшилтэт зохицуулалтыг уламжлан хадгалах, улмаар тус төсөлд орхигдоод байсан улс төрийн намын орлого, хандивын ил тод болгох, хараат бус хяналтын механизмыг бурдуулэх, сонгуулийн компанийт ажлын санхүүжилтэд иргэний нийгмийн хяналтын оролцоог хангахад чиглэсэн зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.</p> |
| <b>Гол зорилт</b>  | <p>Улс төрийн намын санхүүжилтийг ил тод, хариуцлага, хяналттай болгох чиглэлээр эрх зүйн орчинг сайжруулах, тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох.</p>   |
| <b>Үйл ажиллагааны товч тодорхойлолт<br/>/140 тэмдэгтүүн хязгаартай/</b> | <p>Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн найруулах, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах ажлыг эрчимжүүлэх; хуулийн төслийг нэн даруй УИХ-аар хэлэлцүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авч ажиллах;</p> <p>Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэх, батлуулах чиглэлээр нэлөөллийн үйл ажиллагааг НЗТ-ийн талуудын оролцоотой өргөн хүрээнд зохион байгуулна.</p>  |
| <b>НЗТ-ийн аль сорилтод хамаатай болох</b>                               | <p>Төрийн үйл ажиллагааны шударга байдлыг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх;</li> <li>✓ Ил тод нээлттэй байдал;</li> <li>✓ Хариуцлагатай байдал;</li> <li>✓ Иргэдийн оролцоо.</li> </ul>  |
| <b>Хамаарал<br/>/НЗТ-ийн зарчмуудад нийцэж байгаа эсэх/</b>              | <p>Улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, хяналт, хариуцлагыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангахтай холбоотой зохицуулалтыг тусгасан Улс төрийн намын тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна.</p> <p>Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн ач холбогдлыг танилцуулах ажлыг өргөн хүрээнд /шийдвэр гаргагчид болон олон нийт, иргэний нийгэм, улс төрийн намуудад чиглүүлэн/ зохион байгуулж, олон нийтийн шаардлагыг өргөжүүлэх замаар хуулийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явцыг эрчимжүүлэх нөхцөлийг бурдуулсэн байна.</p>   |
| <b>Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд</b>                                  | <p>Эхлэх хугацаа</p>  |
|  | <b>Дуусах хугацаа</b>   |

|   |            |            |
|---|------------|------------|
| /Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа/  |            |            |
| 1. Улс төрийн намын тухай хуульд "улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох"-той холбоотой зохицуулалтыг тусгах чиглэлээр судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах, УИХ-д өргөн мэдүүлэх; | 2019.01.15 | 2019.12.20 |
| 2. Олон нийтийг мэдээллээр хангах, тэдний дэмжлэгийг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг танилцуулах, санал авах хэлэлцүүлгийг олон талт оролцонд тулгуурлан өргөн хүрээнд зохион байгуулах;  | 2019.01.15 | 2020.01.30 |
| 3. Улс төрийн намуудаас хуулийн төслийг дэмжих, олон нийтийн өмнө үүрэг амлалт авах ажлыг зохион байгуулах;   | 2019.01.15 | 2019.06.30 |
| 4. Хуулийн төслийг батлуулах хүртэл НЗТ-ийн талуудтай хамтран нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.   | 2019.06.30 | 2020.6.30  |

### НЗТ-ИЙН СОРИЛТ: КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА, ЭРГЭН ТАЙЛАГНАЛЫГ САЙЖРУУЛАХ

| ЧИГЛЭП: Компанийн засаглал   |  |
|--|--|
| ҮҮРЭГ АМЛАЛТЫН ДУГААР, НЭР: 9 Төрийн болон нийтийн өмчит компанийн засаглалыг сайжруулах               |  |
| Үйл ажиллагааг эхлэх дуусгах огноо<br>/Шинээр дэвшиүүлж буй зорилтуу эсээл хэрэгжиж буй зорилт уү/     | 2019.01.15-2021.01.15<br>Хэрэгжиж буй зорилт   |
| Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг<br>Хэрэгжүүлэгч байгууллагаас<br>кариуцсан хүний нэр, албан тушаал | Засгийн газрын хэрэг эрхлэх газар  |
| Газар, хэлтсийн нэр  | Дэд дарга  |
| И-мэйл хаяг  | ЗГХЭГ-ын төрийн өмчит компани хариуцсан дэд дарга  |
| Утас   | -  |
| Бусад оролцогч талууд  | Хууль зүй асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төсөв, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн |

|  |  |  |
|--|--|--|
|  |  | харилцааны газар, Санхүүгийн зохицуулах хороо, Нутгийн захиргааны байгууллага  |
| Иргэний нийгмийн байгууллага<br>Хувийн хэвшил<br>Хэвлэл мэдээлэл |  | Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Монголын хөрөнгийн бирж ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК, Эрдэнэс МГЛ ХХК, МҮХАҮТ, МАОЭНХ, Сайн Засаглал сэтгүүл ХМХ, Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, МҮОНРТ   |
| Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт                    |  | <p>Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого, "Үндэсний үйлдвэрлэл", Төрийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтуудын хүрээнд төрийн болон нийтийн өмчит компанийн засаглал, нийгмийн хариуцлагыг сайжруулах эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд, Засгийн газрын 2017 оны 114-р тогтоолоор батлагдсан Авиалгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн холбогдох зорилтыг хангах зорилгоор төрийн болон нийтийн өмчит компанийн засаглалын сайжруулах шаардлага бий болсон.</p> <p>Засгийн газрын 2011 оны 69-р тогтоолоор "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" батлагдаж хэрэгжилтийг СЗХ-ны дэргэд Компанийн засаглалын үндэсний зөвлөл байгуулагдаж 2016 оноос Засгийн газрын тэмдэглэлээр бие даасан хараат бус байдлаар байгуулагдаж компанийн засаглалын чиглэлээр мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулж ирсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах санаачлаг хэд хэдэн удаа гарч байсан хэдий ч одоог хэр нь дорвитой өөрчлөлт орж чадаагүйгээс холбогдох хуулиудтай зөрчилдсөөр байна. Иймд Төрийн болон нийтийн өмчийн талаар төрөөс баримтлах үзэл баримтлал нэн тэргүүнд батлагдах шаардлагатай байгаа.</li> <li>- Компанийн тухай хуулийн 75.8 дах заалтын дагуу төрийн болон нийтийн өмчит компанийн ТҮЗ-ийн дарга, гишүүд нь засаглалын сургалтад сууж гэрчилгээ авдаг. Одоогийн байдлаар 6000 гаруй иргэд анхан шатны гэрчилгээ олгох сургалтад хамрагдсан хэдий ч ахисан түвшний гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөр боловсруулж хамрагдуулах хэрэгцээ бий болсон.</li> <li>- Төрийн болон нийтийн өмчит компанийн засаглал, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, засаглалын сургалтад хамрагдсан</li> </ul> |

|  |  |
|--|--|
|  | <p>Хүмүүсийн нэгдсэн мэдээллийн бааз, нийтийн албан хаагчдын мэдээллийг холбогдох төрийн байгууллагын мэдээллийн баазтай холбож төрийн, олон нийтийн хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байгаа. Авилгын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.4.5-д Гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдийн талаар олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог Компанийн засаглалын үндэсний портал сайтаар дамжуулан тогтмол мэдээлэх нь үр дүнтэй хэрэгжих боломжтой.</p>  |
|  | <ul style="list-style-type: none"> <li>- Компаниудын засаглалд үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэхгүйгээр төрийн болон нийтийн өмчит компаниуд өөрсдийн засаглалыг сайжруулахад ач холбогдол өгөхгүй байгаа. Компанийн засаглалыг мэргэжлийн, хөндлөнгийн зүгээс үнэлэх, сайжруулах талаар зөвлөгөө өгч холбогдох журмуудад өөрчлөлт оруулахад төртэй хамтран ажиллах шаардлагатай байгаа. Олон улсын түвшинд компаниудын зээлжих зэрэглэл тогтоож үнэлгээ өгдөг бөгөөд энэ нь бизнесийн нэр хүнд, хөрөнгө оруулалт татахад чухал хөшүүрэг болдог.</li> <li>- Компанийн тухай хуулийн 79.2-т зааснаар хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг цахимжуулах, олон нийтийн оролцоог дээшлүүлэх шаардлага хэвээр байна.</li> </ul> |
|  | <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон нийтийн өмчит компанийн нийгмийн хариуцлага, дотоод аудит, эрсдэлд сууринсан хяналтын тогтолцоог бий болгоход ОУ-ын комплаенс удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байdag.</li> </ul>   |
| <p><b>Гол зорилт</b></p>   | <p>Төрийн болон нийтийн өмчит компанийн засаглалыг сайжруулах</p>  |
| <p><b>Үйлажиллагааны товч тодорхойлолт<br/>(140 тэмдээгийн хязгаартай)</b></p> | <p>Төрийн болон нийтийн өмчит компанийн засаглалыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн орчныг сайжруулах, засаглалын ахисан түвшинд мэргэшүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангдуулах, засаглалын хөндлөнгийн үнэлгээг хийж зөвлөмж өгөх, үр дүng тайлагнах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шударга зарчмаар сонгох, нийгмийн хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг бэхжүүлэхэд оршино.</p>   |
| <p><b>НЭТ-ийн аль сорилтод хамаатай болох</b></p>                              | <p>Компанийн хариуцлага, эргэн тайлагналтыг нэмэгдүүлэх</p>  |
| <p><b>Хамаарал:</b><br/>(НЭТ-ийн зарчмуудад нийцэх байдал)</p>                 | <ul style="list-style-type: none"> <li>✓ Ил тод, нээлттэй байдал</li> <li>✓ Хариуцлагатай байдал</li> <li>✓ Иргэдийн оролцоо</li> </ul>  |

|  |   |                       |
|--|---|-----------------------|
| <p><b>Үйл ажиллагааны зорилтот үр дүн:</b><br/> <i>/Засагийн газрын үйл ажиллагааг хэрхэн илүү нээлттэй болгож, саижруулах талаар төвчхөн тооорхойлох/</i></p> | <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан хууль батлагдаж мөрдөгднө.</li> <li>- Төрийн болон нийтийн өмчит компанийн хамтын удирдлагыг хэрэгжүүлэх удирдлагын мэдлэг, чадавх дээшилж идэвх оролцоо нэмэгдэнэ.</li> <li>- Компанийн засаглал, санхүү, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал хангагдаж олон нийтийн хяналт сайжирна.</li> <li>- Компаниуд өөрсдийн болон хөндлөнгийн үнэлгээ хийдэж үйл ажиллагаа сайжирч хариуцлага нэмэгдэнэ.</li> <li>- Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалт цахимаар ил тод, нээлттэй болж олон нийтийн оролцоо нэмэгдэнэ.</li> <li>- Компанийн нийгмийн хариуцлага, дотоод хяналт сайжирснаар санхүүгийн үр ашиг дээшилнэ.</li> <li>- Компанийн засаглал сайжирснаар хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах, бага хүүтэй хөнгөлттэй нөхцөлтэй зээл авах зэрэг санхүүгийн хөшүүрэг бий болж эдийн засагт оруулах хувь нэмэр дээшилнэ.</li> </ul> |                       |
| <p><b>Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд</b><br/> <i>/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа/</i></p>  | <b>Эхлэх хугацаа</b>  | <b>Дуусах хугацаа</b> |
| 1. Төрийн болон нийтийн өмчийн засаглалыг сайжруулах эрх зүйн орчинг сайжруулах  | 2019.01.01  | 2019.06.30            |
| 2. Компанийн засаглалын ахисан түвшиний гэрчилгээ олгох мэргэшсэн сургалтыг бий болгож чадавхижуулах   | 2019.01.01  | 2020.06.30            |
| 3. Төрийн болон нийтийн өмчийн засаглал, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангуулах  | 2019.01.01  | 2020.12.30            |
| 4. Компанийн засаглалын хөндлөнгийн үнэлгээг хийж зөвлөмж өгөх, үр дүнг тайлагнах тогтолцоог бий болгох  | 2019.01.01  | 2019.12.30            |
| 5. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалтыг олон нийтийн оролцоонд тулгуурлан нээлттэй, ил тод зохион байгуулах нэгдсэн тогтолцоог бий болгох           | 2019.01.01  | 2020.12.30            |
| 6. Төрийн болон нийтийн өмчит компанийн нийгмийн хариуцлага, дотоод аудит, эрсдэлд сууринсан хяналтын тогтолцоог бий болгох                                    | 2019.01.01  | 2021.01.01            |

**НЭТ-ИЙН СОРИЛТ: БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ**

| <p align="center"><b>ЧИГЛЭЛ: БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫН САЙЖРУУЛАХ</b></p> <p align="center">ҮҮРЭГ АМЛАЛТЫН ДУГААР, НЭР: 10. Ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах</p> |   |   |
|--|---|---|
| <p><b>Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо<br/>Ишинээр дэвшиүүлж буй зорилт уу эсвэл хэрэгжих буй зорилт уу?</b></p>  |   | 2019.01.15-2021.01.15   |
| <b>Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг</b>   | Хэрэгжиж байгаа зорилт  |   |
| <b>Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр, албан тушаал</b>  | ЗГХЭГ, Уул уурхай хунд, үйлдвэрийн яам ОҮИТБС-ын үндэсний зөвлөлийн дарга Ерөнхий сайд<br>УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга  |   |
| <b>Газар, хэлтсийн нэр</b>   | УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газар<br>damba@mmhi.gov.mn  |   |
| <b>И-мэйл хаяг</b>   |   |   |
| <b>Утас</b>  | 99187723  |   |
| <b>Бусад оролцогч талууд</b>   | <b>Яам, агентлаг</b>  | Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн өрөнхий газар, Монгол банк, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, АМГТГ  |
|  | <b>Иргэний нийгмийн байгууллага<br/>Хувийн хэвшил<br/>Хэвлэл мэдээлэл</b>   | Төлсөн авсанаа нийтэл эсвэл, Нээлттэй нийгэм форум, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын алба |
| <b>Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт</b>   | Олборлох салбарт үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах асуудал нь Монгол Улсын НЭТ-ийн 2016-2018 оны YAYT-ний үндсэн зорилтын нэг байсан бөгөөд НЭТ-ийн хөндлөнгийн шинжээчдийн үнэлгээгээр ОД үнэлгээ авч ОУ-ын түвшинд сайн жишиг болж үнэлэгдсэн гурван зорилтын нэг юм. Түүнчлэн Монгол Улс 2006 оноос нэгдэн орж хэрэгжүүлж буй Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг санаачилга (ОҮИТБС)-ын заавал биелүүлэх шаардлага юм. Энэ хүрээнд 2017 онд ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2020 онд хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны Замын зураг батлагдаж, Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай, Ашигт малтмалын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эцсийн өмчлөгчийг бүртгэх шаардлага тусгагдаад байна. Гэсэн ч дээрх хуулийн хэрэгжилт хангалтгүй бөгөөд эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин бүрдээгүй байсаар байна. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.6.5 дахь хэсэгт |   |

|   |   |                  |               |
|---|---|------------------|---------------|
|   | <p>“ОҮИТБ-ыг хангах” зорилт дэвшиүүлээд байгаа юм. Иймээс ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил байдлыг хангах чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, “Эцсийн өмчлөгчийн мэдээллийн цахим сан”-г бүрдүүлж, олон нийтэд нээлттэй болгох шаардлага хэвээр байна.</p> <p>Ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчны бий болгож, “Эцсийн өмчлөгчийн цахим мэдээллийн сан”-г бүрдүүлж, олон нийтэд нээлттэй болгосноор олборлох салбарт авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулж, салбарын засаглалыг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулна.</p>            |                  |               |
| <b>Гол зорилт</b>   | Ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчны бий болгож, “Эцсийн өмчлөгчийн цахим мэдээллийн сан”-г бүрдүүлж, олон нийтэд нээлттэй болгох  |                  |               |
| <b>Үйл ажиллагааны товч тодорхойлолт</b><br><i>/140 тэмдэгтийн хязгаартай/</i>                        | Олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч, тэдгээрийн оператор, ханган нийлүүлэгч, баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх, цахим мэдээллийн сангаар дамжуулан олон нийтэд АХЭӨ-ийг нээлттэй болгох  |                  |               |
| <b>НЭТ-ийн аль сорилтод хамаатай болох</b>  | Төрийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод, байдлыг нэмэгдүүлэх<br>Шударга хариуцлагатай байдлыг бэхжүүлэх<br>Авлигатай тэмцэх   |                  |               |
| <b>Хамаарал:</b><br><i>/НЭТ-ийн зарчмуудад нийцэх байдал/</i>   | <ul style="list-style-type: none"> <li>✓ Ил тод, нээлттэй байдал</li> <li>✓ Хариуцлагатай байдал</li> <li>✓ Иргэдийн оролцоо</li> <li>✓ Технологи, инноваци</li> </ul>  |                  |               |
| <b>Үйл ажиллагааны зорилтот үр дүн</b>  | <ol style="list-style-type: none"> <li>1. Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчин бүрдсэн байна.</li> <li>2. Эцсийн өмчлөгчийн цахим мэдээллийн санг бүрдүүлж, нийтэд нээлттэй болно</li> <li>3. Монол Улсын Засгийн газрын ОҮИТБС-ын хүрээнд хүлээсэн АХЭӨ-ийг 2020.01.01-ээс нээлттэй болгосон байх амлалт хэрэгжсэн байна.</li> <li>4. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.6.5 дахь хэсгийн ОҮИТБ-ыг хангах зорилт хэрэгжихэд хувь нэмэр оруулна.</li> </ol> |                  |               |
| <b>Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд</b><br><i>/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх гол зорилт ажиллагаа/</i> | <table border="1" style="width: 100%;"> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">Эхийн<br/>хугацаа</td> <td style="text-align: center; padding: 5px;">Дусах хугацаа</td> </tr> </table>   | Эхийн<br>хугацаа | Дусах хугацаа |
| Эхийн<br>хугацаа  | Дусах хугацаа   |                  |               |

|  |            |            |
|--|------------|------------|
| 1. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүд, Засгийн газар холбогдох яамд, уул уурхайн компанийн төлөөлөл, иргэний нийгмийн төлөөллийн хамтарсан уулзалт хийж ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин бий болгох талаар уулзалт, хэлэлцүүлэг хийх | 2019.01.15 | 2019.02.25 |
| 2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулах, шаардлагатай тооцоо, судалгаа, үнэлгээг хийх, хуулийн төслийг батлах   | 2019.01.15 | 2019.07.01 |
| 3. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулж, нэгдсэн цахим санд байршуулж, нийтэд нээлттэй болгох   | 2019.06.01 | 2019.10.01 |
| 4. Ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн ил тод байдлын шаардлагыг холбогдох хуулийн этгээдүүд, бусад талуудад таниулах сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах   | 2019.07.01 | 2021.01.01 |
| 5. Хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дунд хугацаанд болон эцсийн үнэлгээ хийх  | 2019.11.01 | 2021.01.15 |

| ЧИГЛЭЛ: БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫН САИЖРУУЛАХ<br>ҮҮРЭГ АМЛАЛТЫН ДУГААР НЭР: 11. Гэрээний ил тод байдлыг хангах |  |
|---|--|
| Үйл ажиллагааг эхлэх, дуусгах отноо<br>/Шинээр дэшшүүлж буй зорилт уу эсвэл хэрэгжиж буй зорилт уу?/              | 2019.01.15-2021.01.15<br>Хэрэгжиж буй зорилт   |
| Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг   | Уул уурхай хүнд, үйлдвэрийн яам (УУХҮЯ)<br>Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) |
| Хэрэгжүүлэгч байгууллагаас<br>хариуцсан хүний нэр,<br>албан тушаал  | А.Эрдэнбат /УУХҮЯ/<br>Ц.Цэгц /АМГТГ/   |
| Газар, хэлтсийн нэр<br>И-мэйл хаяг  | УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газар,   |
| Утас  | 88075315 /А.Эрдэнэбат/<br>99880212 /Ц.Цэгц/  |

|                                      |   |  |
|--------------------------------------|---|--|
| <b>Бусад<br/>оролцогч<br/>тaluуд</b> | <b>Яам, агентлаг</b>  | ЗГХЭГ, Эрдэнэс МГЛ<br>Хууль зүй, дотоод хэргийн яам,<br>АМГТГ<br>Байгаль орчин, аялал жуулчлалын яам   |
|                                      | <b>Иргэний нийгмийн<br/>байгууллага<br/>Хувийн хэвшил<br/>Хэвлэл мэдээлэл</b> | Төлсөн авсаная нийтэл эвсэл, Нээлттэй нийгэм форум, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын алба, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн  |
|                                      | <b>Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын<br/>тодорхойлолт</b>                      | Олборлох салбарт гэрээний ил тод байдлыг хангах асуудал нь Монгол Улс 2006 оноос нэгдэн орж хэрэгжүүлж буй Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг санаачилга (ОҮИТБС)-ын стандартын шаардлагын нэг төдийгүй Монгол Улсын НЗТ-ийн 2016-2018 оны YAYT-ий үндсэн зорилтын нэг байсан юм. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.1.6.5 дахь хэсэгт "ОҮИТБ-ыг хангах" зорилт дэвшүүлсэн. Энэ хүрээнд <a href="http://www.iltodgerree.mn">www.iltodgerree.mn</a> цахим сан байгуулгадаж, олборлох салбарт байгуулгадсан тодорхой тооны гэрээг байршуулж эхлээд байгаа боловч гэрээний ил тод байдлыг хангах эрх зүйн орчин бүрдээгүйгээс ил тод байдлыг цаашид тогтвортой хангах баталгаа байхгүй байна. Гэрээний ил тод байдал нь ОҮИТБ-ын тайлангаар нээлттэй болох болможтой хэдий ч ил тод байдлын тайлан гаргах үүргээ хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгжид хүлээлгэх хуулийн хариуцлага сул, холбогдох төрийн байгууллагуудын үүрэг хариуцлага хуульчлагдаагүйгээс тайлан гаргагч аж ахуйн нэгжийн тоо сүүлийн жилүүдэд буурч, төрийн байгууллагуудын идэвх оролцоо хангалтгүй байна. Байгалийн баялаг ашиглах гэрээ нь Захиргааны ерөнхий хуулиар захиргааны гэрээ болж байгаа ч сонсох ажиллагаа явуулж иргэдийн оролцоог хангахгүй байсаар байна. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, зэрэг орд ашиглах үйл ажиллагааны гол нөхцлүүдийг тодорхойлдог үндсэн гэрээнүүд ил тод болоогүй хэвээр байна. Мөн Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, тогтвортжуулалтын гэрчилгээ, Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан |

|  |   |
|--|---|
|  | <p>бүхий газарт явагдаж буй уул уурхайн үйл ажиллагааны нөхөн сэргээлтийн гэрээ, Газар ашиглах гэрээ, Ус ашиглах гэрээ зэрэг гэрээнүүдийг ил тод болгоход төрийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа дутмаг хэвээр байна.</p> <p>ОҮИТБС-ын хүрээнд салбарын засаглалыг сайжруулах, ил тод байдал, иргэдийн оролцоог бий болгох зорилго бүхий “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл”-ийг боловсруулж, 2015 онд УИХ-д өргөн барьсан боловч батлагдсангүй. Иймд үндэсний хууль тогтоомжийг ОҮИТБС-ын стандарт шаардлагад нийцүүлэх замаар цаашид ил тод байдлыг бүрэн, тогтвортой хэрэгжүүлэх эрх орчныг бий болгох шаардлага хэвээр байна.</p>   |
| <b>Гол зорилт</b>  | <p>ОҮИТБС-ын стандарт шаардлагыг дотоодын хууль тогтоомжид тусгах замаар цаашид олборлох салбарт ил тод байдлыг бүрэн дүүрэн, тогтвортой хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар байгалийн баялаг ашиглахтай холбоотой бүх төрлийн гэрээг нийтэд нээлттэй болгосноор олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэн, авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулж, салбарын засаглалыг сайжруулах</p>   |
| <b>Үйл ажиллагааны товч тодорхойлолт<br/>(140 тэмдэгтийн хязгаартай)</b> | <p>Олборлох салбарт байгуулдаг дараах төрлийн гэрээг нийтэд нээлттэй болгох. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгө оруулалтын гэрээ</li> <li>- Бүтээгдэхүүн хуваах гэрээ</li> <li>- Орд ашиглах гэрээ</li> <li>- Бүтээгдэхүүн борлуулалтын гэрээ</li> <li>- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ</li> <li>- Тогтвржуулалтын гэрчилгээ</li> <li>- Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ</li> <li>- Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бүтээгдэхүүн борлуулалтын гэрээ хэлцэл</li> <li>- Баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлд худалдан авсан бүтээгдэхүүний гэрээ хэлцэл</li> <li>- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт явагдаж буй уул уурхайн үйл ажиллагааны нөхөн сэргээлтийн гэрээ,</li> </ul> |

|  | <ul style="list-style-type: none"> <li>- Газар ашиглах гэрээ</li> <li>- Ус ашиглах гэрээ гэх мэт.</li> </ul>  |               |                |            |            |
|--|---|---------------|----------------|------------|------------|
| <b>НЭТ-ийн аль сорилтод хамаатай болох</b>   | <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод, байдлыг нэмэгдүүлэх</li> <li>- Шударга хариуцлагатай байдлыг бэхжүүлэх</li> <li>- Авиалгатай тэмцэх</li> </ul>  |               |                |            |            |
| <b>Хамаарал:</b><br><i>/НЭТ-ийн зарчмуудад нийцэх байдал/</i>  | <input checked="" type="checkbox"/> Ил тод, нээлттэй байдал<br><input checked="" type="checkbox"/> Хариуцлагатай байдал<br><input checked="" type="checkbox"/> Иргэдийн оролцоо<br><input checked="" type="checkbox"/> Технологии, инновации  |               |                |            |            |
| <b>Үйл ажиллагааны зорилтот ур дун</b>   | <p>Олборлох салбарт гэрээний ил тод байдлыг хангах шаардлага хуульчлагдсан байна.<br/>Гэрээний мэдээллийн <a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a> цахим сан бүрдэж, ил тод болсон байна.<br/>Төрийн болон төрийн өмчийн оролцоотой Эрдэнэс МГЛ ХХК- ил тод, нээлттэй байдлын үзүүлэлтээр бизнесийн манлайлал бий болсон байна.<br/>Авиалгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.6.5 дахь хэрэгжилтэд хувь нэмэр оруулна.</p> |               |                |            |            |
| <b>Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд</b><br><i>/Зорилтын хурээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа/</i>   | <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="text-align: center;">Эхлэх хугацаа</th> <th style="text-align: center;">Дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center;">2019.01.15</td> <td style="text-align: center;">2019.07.01</td> </tr> </tbody> </table>  | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | 2019.01.15 | 2019.07.01 |
| Эхлэх хугацаа  | Дуусах хугацаа  |               |                |            |            |
| 2019.01.15   | 2019.07.01  |               |                |            |            |
| 1. Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай бие даасан хууль гаргах болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах боломжуудыг судлан шаардлагатай тооцоо, судалгаа, үнэлгээг хийх, эрх зүйн орчин бүрдүүлэх | 2019.01.15  | 2019.07.01    |                |            |            |
| 2. <a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a> цахим хуудсыг тогтмол, тогтвортой хариуцан ажиллуулах үүргийг УУХҮЯ, АМГТГ, ОҮИТБС-ын ажлын албандаа даатгах эрх зүйн орчныг бүрдүүлэх                   | 2019.01.15  | 2019.04.01    |                |            |            |
| 3. Байгалийн баялаг ашиглах гэрээ нь Захиргааны өрөнхий хуулиар захиргааны гэрээ болж байгааг гэрээний талуудад ойлгуулах, иргэдийн оролцоог хангах, хэрэгжилтэд үнэлгээ хийх нөлөөллийн ажил                        | 2019.01.15  | 2019.07.01    |                |            |            |
| 4. Хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дунд хугацааны болон эцсийн үнэлгээ хийх  | 2019.11.01  | 2020.06.01    |                |            |            |

**ЧИГЛЭЛ: Төрийн мэдээллийн ил тод байдал**

**ЗОРИЛТОТ УИЛ АЖИЛЛАГААНЫ ДУГААР, НЭР: 12. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан**

|  |  |
|--|--|
| <b>Уил ажиллагааг эхлэх, дуусгах огноо</b><br>ЛШинээр дэвшүүлж буй зорилт уу<br>эсвэл хэрэгжиж буй зорилт уу?/ | 2019.01.15-2021.01.15<br>Шинээр дэвшүүлж буй зорилт  |
| <b>Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг</b>   | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар / ЗГХЭГ /  |
| <b>Хэрэгжүүлэгч байгууллагаа<br/>хариуцсан хүний нэр, албан тушаал</b>   | ЗГХЭГ-ын ХШУДАГ-ын дарга Э.Бат-Идэр,<br>Референт Ш.Цэцэг-Өлзий   |
| <b>Газар, хэлтсийн нэр</b>   | Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар  |
| <b>И-мэйл хаяг</b>   | e.batider@cabinet.gov.mn   |
| <b>Утас</b>  | 91992595, 51261163   |
| <b>Бусад оролцогч талууд</b>   | <b>Яам, агентлаг</b><br>Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага / Яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ /<br><br><b>Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага</b><br>“Ухаалаг Засаглал” ТББ   |
| <b>Шийдвэрлэхээр зорых буй асуудлын тодорхойлолт</b>   | ЗГХЭГ нь 2012 оноос <a href="http://www.unelgee.gov.mn">www.unelgee.gov.mn</a> буюу Төрийн мэдээллийн сүлжээг хөгжүүлсээр ирсэн бөгөөд тус систем нь Засгийн газрын 2013 онд 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн голлох ажлуудын нэг байсан билээ.<br><br>Системийн зорилго: Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төрийн албаны тухай / Шинэчилсэн найруулга / хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл |

|   |  |
|---|--|
|   | <p>ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлагдсанаар бодлогын баримт бичиг боловсруулах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, үнэлж дүгнэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалд томоохон өөрчлөлтүүд орсон.</p> <p>Иймээс Төрийн мэдээллийн сүлжээг /Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан/ дээрх хууль тогтоомжид нийцүүлэн цогц байдлаар хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.</p> |
| <p><b>Гол зорилт</b></p>  | <p>Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан буюу <a href="http://www.unelgee.gov.mn">www.unelgee.gov.mn</a> системийг хөгжүүлэх замаар</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төрийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх</li> <li>2. Засгийн газрын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгох</li> </ol> <p>Захиргааны байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, хариуцлагыг сайжруулах</p>                               |
| <p><b>Үйл ажиллагааны товч тодорхойлолт</b><br/><i>/140 тэмдэгтийн хязгаартай/</i></p>  | <p>Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг хууль тогтоомжид нийцүүлэн цогц байдлаар хөгжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгох</p>  |
| <p><b>НЭТ-ийн аль сорилтод хамаатай болох</b><br/><b>Хамаарал:</b><br/><i>/ НЭТ-ийн зарчмуудад нийцэх байдал /</i></p>  | <p>1. Төрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Ил тод, нээлттэй байдал</li> <li>✓ Хариуцлагатай байдал</li> <li>✓ Иргэдийн оролцоо</li> <li>✓ Технологи, инноваци</li> </ul>   |
| <p><b>Үйл ажиллагааны зорилтот үр дүн:</b><br/><i>/Засгийн газрын үйл ажиллагааг хэрхэн шилж нээлттэй болгож, сайжруулах талаар төвчхөн тодорхойлох /</i></p> | <p>-Хөгжлийн төлөвлөлт, төсөвлөлтийг өндөр түвшинд боловсруулдаг болж, нэгдсэн байдал хангагдана. Урт, дунд, богино хугацааны төлөвлөлтийн уялдаа холбоо сайжирна.</p> <p>-Ажлын гүйцэтгэлийг цогц байдлаар тайлагнадаг болно. Урьдчилсан, явцын болон төгсгөлийн хяналт сайжирна.</p> <p>-Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирч, үр дүнд сууринласан удирдлагын тогтолцоо бий болно.</p>  |

| Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд<br>/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх<br>гол бүйл ажиллагаа/   | Эхлэх<br>хугацаа | Дуусах хугацаа |
|--|------------------|----------------|
| 1. Системийн цаашдын хөгжүүлэлт шаардагдах зардалыг тодорхойлж санхүүжилт олох.  | 2019.01.15       | 2020.10.01     |
| 2. Системийн нээлттэй хэсгийг хөгжүүлж төрийн мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах.  | 2019.01.15       | 2019.07.01     |
| 3. "Төрийн албан хаагчийн чадавхийг бэхжүүлэх" системийг хөгжүүлэх:<br>Систем №1. Цахим сургалтын систем<br>Систем №2. Мэдлэгийн нэгдсэн сан                           | 2019.06.01       | 2021.01.15     |
| 4. Урт болон богино хугацааны Бодлогын баримт бичиг, Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа зэрэг баримт бичгүүдийг системд бүртгэх, гүйцэтгэлийг үнэлэх бололцоог хангах. | 2019.06.01       | 2019.12.01     |

### НЭТ-ИЙН СОРИЛТ: УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БУУРУУЛАХ

| ЧИГЛЭЛ: Хүрээлэн буй орчны аюулгүй байдал  |   |   |
|--|---|---|
| <b>ҮҮРЭГ АМЛАЛТЫН ДУГААР, НЭР: 13. Хог хаягдлын менежментэд манлайллыг бий болгох, УТХГН-ийн засаглалыг сайжруулах</b> |   |   |
| <b>Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо<br/>(Шинээр дэвшиүүлж буй зорилт уу эсвэл хэрэгжиж буй зорилт уу?)</b>          |   | 2019.01.15-2021.01.15   |
| <b>Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг<br/>Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр, албан тушаал</b>            |   | Шинээр дэвшиүүлж буй зорилт<br>Байгаль орчин, аялал жуулчлалын яам  |
| <b>Газар, хэлтсийн нэр<br/>И-мэйл хаяг</b>   |   | Д.Энхбат  |
| <b>Утас</b>  |   | enkhbataltangerel@gmail.com   |
| <b>Бусад оролцогч талууд</b>   | <b>Яам, агентлаг</b>  | 91910160  |
|  | <b>Иргэний нийгмийн байгууллага<br/>Хувийн хэвшил<br/>Хэвлэл мэдээлэл</b> | ЗГ, Яам, агентлаг, аймаг нийслэлийн ЗДТГ Томоохон 50 үйлдвэрийн газар Хэвлэл мэдээллийн 30 байгууллага            |
|  |   | Хил хязгааргүй алхам бусад ТББ Хог хаягдлыг менежментэд оролцогч ААН МҮОНРТ бусад хэвлэл мэдээллийн байгууллагууд |

|   |   |
|---|---|
| <p><b>Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт</b></p>   | <ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлыг боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа, нийтийн үйлчилгээг хэрхэн ямар нөхцөлтэй гэрээгээр үзүүлж байгаа мэдээллийн нэгдсэн сан байхгүйгээс үүсч байгаа асуудал</li> <li>Хог хаягдлыг ялган ангилж хаях талаар нийгмийн соёл тогтоогүйгээс үүсч буй уур амьсгалын өөрчлөлт аюулгүй байдалд нөлөөлж буй сөрөг нөлөөлөллийн бууруулах</li> <li>Бүх шатны төрийн байгууллага, томоохон 50 үйлчилээний байгууллагын түвшинд хог хаягдлыг ялган ангилах соёлыг манлайлан хэрэгжүүлэх замаар төрийн албан хаагчид, үйлдвэрийн ажилчид, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоотойгоор дараагийн шатанд олон нийтийн хандлагад нөлөөлж</li> <li>Хог хаягдлын менежмент, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар Улсын тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх бүхий аж ахуй нэгжүүдийн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах. Мөн УТХГН-т газар олгох үйл явц, газар ашиглах эрх бүхий этгээдүүдийн мэдээлэл хаалттай байна.</li> </ul> |
| <p><b>Гол зорилт</b></p>  | <p>Хог хаягдлыг эх үүсвэрт нь ангилан ялгах соёлыг төрийн байгууллагууд бусад нийгмийн нөлөө бүхий ААН-үүд манлайлан хэрэгжүүлэх замаар хог хаягдлын менежментийн хандлагад нөлөөлж уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах.</p>   |
| <p><b>Үйл ажиллагааны товч тодорхойлолт<br/>(140 тэмдэгтийн хязгаартай)</b></p>   | <ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлыг зөв менежментийг төр-хувийн түншлэл, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлж иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчинд нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулах.</li> <li>УТХГН-ийн эко системийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг бууруулах.</li> </ul>   |
| <p><b>НЗТ-ийн аль сорилтод хамаатай болох</b></p>   | <p>Эрүүл аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, ил тод нээлттэй байдал, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх</p>   |
| <p><b>Хамаарал:</b><br/><i>/НЗТ-ийн зарчмуудад нийцэх байдал/</i></p>   | <p>✓ Ил тод, нээлттэй байдал<br/>✓ Хариуцлагатай байдал<br/>✓ Иргэдийн оролцоо</p>  |
| <p><b>Үйл ажиллагааны зорилтот үр дүн:</b><br/><i>/Засгийн газрын үйл ажиллагааг хэрхэн илүү нээлттэй болгож сайжруулах талаар төвчхөн тодорхойлох/</i></p> | <p>Төр-хувийн хэвшлийн түншлэл, манлайллаар хог хаягдлыг менежментийг сайжруулж иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчныг дээшлүүлсэн байна.</p>  |

| <b>Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд<br/>/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх<br/>гол үйл ажиллагаа/</b>  | <b>Эхлэх хугацаа</b> | <b>Дуусах хугацаа</b> |
|---|----------------------|-----------------------|
| 1. Хог хаягдлыг эх үүсвэр, бүтцийн болон төсвийн зэрэг цогц судалгаа гаргах, мониторинг хийх /терийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, томоохон 50 үйлдвэрлэл эрхлэгч ААН/  | 2019.01.15           | 2019.09.20            |
| 2. УТХГН-т газар эзэмшигчдийн мэдээллийг нээлттэй болгох улмаар тэдгээрийн хог хаягдлын менежментийн хэрэгжилтэд үнэлгээ хийж эко системийн өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг ил тод нээлттэй болгосон мэдээллийн нэгдсэн сан бий болгох.  | 2019.01.01           | 2020.02.15            |
| 3. Сонгосон 30 ХМБ, 50 ААН, яам агентлагийн түвшний хэлэлцүүлэг зохион байнуулах.   | 2019.02.20           | 2019.12.15            |
| 4. Хог хаягдлыг ачих, боловсруулах үйлчилгээ үзүүлдэг ААН-үүд, нийтлэг үйлчилгээний газруудын нөөц чадавхийн судалгаа гаргаж, тэдгээрийн түвшинд уулзалт зохион байгуулах, хандлагад нөлөөлөх, үүрэг хариуцлага, гэрээний эргэн тайлагналтыг нэмэгдүүлэх                              | 2019.03.20           | 2019.09.30            |
| 5. Дээрх 3 байгууллага, тэдгээрийн албан хаагчдад нөлөөлөл хийх үүрэг хариуцлага, үр дүнгийн гэрээнд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад оруулах хувь нэмэр үүргийг заасан заалтуудаар нэмэлт оруулж үр дүн, хэрэгжилтийг сурталчлах замаар олон нийтийн мэдлэг ойлголтод нөлөөлэх. | 2019.04.01           | 2021.01.15            |